

Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны ... дүгээр сарын ...-ний өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНД ТАВИХ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоо (цаашид “Мэргэжлийн холбоо” гэх)-д тавигдах шаардлагыг тогтооход оршино.

1.2. Мэргэжлийн холбоог энэ журамд тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг Хорооны хуралдаанаар тодорхойлж, санамж бичиг байгуулан хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.

ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Мэргэжлийн холбоо нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;

2.1.2. гишүүд нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр Хороонд бүртгүүлсэн байх;

2.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй Хороонд бүртгэлтэй Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

2.1.4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7.1.2, 7.1.5, 7.1.6-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй хуулийн этгээдэд дүгнэлт гаргах мэргэжлийн боловсон хүчинтэй байх;

2.1.5. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй, гишүүддээ мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах чадамжтай байх;

2.1.5. сургалтын хөтөлбөр боловсруулж, Хороогоор батлуулсан байх;

2.1.6. мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх;

2.2. Мэргэжлийн холбооны удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;

2.2.2. гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;

2.2.3. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.2.4. хэвийнээс бусад зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

2.2.5.ёс зүйн нэр хүндтэй байх;

2.2.6.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох бусад шалгуурыг хангасан байх.

2.3. Мэргэжлийн холбоо нь Хорооны санал, дүгнэлтэд үндэслэн дараах дүрэм, журмыг бүх гишүүдийн хурлаар батлуулсан байна. Үүнд:

2.3.1.гишүүнээр элсүүлэхэд тавих шаардлага, гишүүнчлэлийн хураамж, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах журам;

2.3.2.гишүүний үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм;

2.3.3.гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих болон гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам;

2.3.4.мэргэжлийн холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам;

2.3.5.гишүүдэд сургалт явуулах, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах журам;

2.3.6. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8-д заасан асуудлаар дүгнэлт гаргах, хянах, мэдээлэх журам.

2.5. Мэргэжлийн холбоо нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

2.4.1. хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг мөрдөх;

2.4.2. гишүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн санал санаачилгыг дэмжих;

2.4.3. гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалт, тайлагнал ил тод нээлттэй байх;

2.4.4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зах зээлийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө судалгаа шинжилгээнд суурилсан байх.